



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны 0᠖ сарын ᠒᠐ өдөр

Дугаар А/᠒23

Улаанбаатар хот

“ Нийслэлийн ерөнхий боловсролын 132 ”
дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 6᠖ дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны ᠖ дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,994,560.0 (хоёр сая есөн зуун ерэн дөрвөн мянга таван зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 97 дугаар сургуулийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургууль (Л.Батсайхан)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиглахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 97 дугаар сургууль (Г.Баярмаа)-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Г.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

Нийслэлийн өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 30 -ны
өдрийн 1225 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Ширээ /6 настай/	модон	2016.10.31	ш	32	46,790.00	1,497,280.00	1,297,632.00	199,648.00	Нийслэлийн ерөнхий боловсролын 97-р сургууль
2	Сандал /6 настай/	модон	2016.10.31	ш	32	46,790.00	1,497,280.00	1,297,632.00	199,648.00	
Нийт шилжүүлэх эд хөрөнгийн дүн							2,994,560.00	2,595,264.00	399,296.00	